

**ЭРҮҮЛ МЭНД, ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ**

2013 оны 11 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 439/А-148

Улаанбаатар хот

Салбар хоорондын зөвлөлийн үйл ажиллагааг өргөжүүлэх тухай

Хүн, малын эрүүл мэндийн болон бусад салбаруудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, үйл ажиллагааны тогтвортой механизмыг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Зоонозын халдварт өвчний хүн, мал эмнэлгийн салбар дундын зөвлөлийг “Нэг эрүүл мэнд” салбар хоорондын зөвлөл болгон өөрчилсүгэй.
2. “Нэг эрүүл мэнд” салбар хоорондын зөвлөлийн болон техникийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар, “Нэг эрүүл мэнд” салбар хоорондын сургалт, судалгааны төвийн үйл ажиллагааны ерөнхий чиглэл, ажлын төлөвлөгөө (2013-2016)-г гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. “Нэг эрүүл мэнд” салбар хоорондын зөвлөлийн бодлого, үйл ажиллагааг зохицуулж ажиллахыг зөвлөлийн дарга, техникийн ажлын хэсгийн дарга нарт үүрэг болгосугай.
4. “Нэг эрүүл мэнд” салбар хоорондын зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг ЭМЯ, ҮХААЯ-ны жил бүрийн төсөвт тусгаж ажиллахыг зөвлөлийн дарга (Эрүүл мэндийн дэд сайд Ж.Амарсанаа), орлогч дарга (Үйлдвэр, хөдөө аж ахуйн дэд сайд Ц.Туваан) нарт даалгасугай.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ЭМЯ, ҮХААЯ-ны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга (Д.Оюунчимэг, Г.Нандинжаргал) нарт үүрэг болгосугай.
6. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэнд, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2010 оны 45/36 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД




Н.УДВАЛ

ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД



Х.БАТТУЛГА



Эрүүл мэнд, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын
2013 оны 73/..... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

1. "Нэг эрүүл мэнд" салбар хоорондын зөвлөлийн бүрэлдэхүүн

Дарга: Эрүүл мэндийн дэд сайд

Орлогч дарга: Үйлдвэр, хөдөө аж ахуйн дэд сайд

Нарийн бичгийн
дарга: ЭМЯ-ны харьяа Зоонозын өвчин судлалын
үндэсний төвийн захирал

Гишүүд:

- ЭМЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
- ҮХААЯ-ны Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын дарга
- БОНХЯ-ны Биоаюулгүй байдлыг хангах үндэсний хорооны нарийн бичгийн дарга (зөвшилцсөнөөр)
- ЗГХА-МЭҮГ-ын дарга
- Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн захирал
- Мал эмнэлгийн хүрээлэнгийн захирал
- Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал
- ХӨСҮТ-ийн Монголын Талбарын Тархвар Судлал Сургалтын захирал
- ОБЕГ-ын Гамшгаас хамгаалах газрын дарга (зөвшилцсөнөөр)
- МХЕГ-ын ХХААҮҮХГ-ын дарга (зөвшилцсөнөөр)
- ДЭМБ-ын Халдварт өвчний хяналт, хариу арга хэмжээ хариуцсан мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)
- НҮБ-ын хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын суурин төлөөлөгч (зөвшилцсөнөөр)



2. Техникийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Дарга: ЗГХА-МЭҮГ-ын дэд дарга, малын ерөнхий эмч

Нарийн бичгийн дарга: ЗӨСҮТ-ийн дэд захирал

Гишүүд:

- ЭМЯ-ны НЭМХ-ийн хүнс болон орчны асуудал хариуцсан мэргэжилтэн
- ЭМЯ-ны НЭМХ-ийн халдварт өвчний хяналт, урьдчилсан сэргийлэлтийн бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
- БОНХЯ-ны Ногоон хөгжлийн стратеги, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)
- ЗГХА-МЭҮГ-ын Ерөнхий эпидемиологич
- Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн дэд захирал, ерөнхий эмч
- МЭХ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга
- ХӨСҮТ-ийн Зооноз, бруцеллёзын тасгийн эрхлэгч
- Монголын талбарын тархвар судлал сургалт хариуцсан мэргэжилтэн
- НЭМҮТ-ийн орчны эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн
- ОБЕГ-ын Гамшгаас хамгаалах газрын хүний гоц халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)
- ОБЕГ-ын Гамшгаас хамгаалах газрын мал, амьтны гоц халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)
- МХЕГ-ын Үндэсний лавлагаа лабораторийн дарга (зөвшилцсөнөөр)
- МХЕГ-ын мал эмнэлгийн хяналтын улсын ахлах байцаагч (зөвшилцсөнөөр)
- МХЕГ-ын эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч (зөвшилцсөнөөр)
- УЦУОШ Хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга (зөвшилцсөнөөр)



Эрүүл мэнд, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын
2013 оны 409 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

“Нэг эрүүл мэнд” салбар хоорондын зөвлөл болон
техникийн ажлын хэсгийн ажиллах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Нэг эрүүл мэнд” салбар хоорондын зөвлөл (цаашид “зөвлөл” гэх)-ийн зохион байгуулалт, үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна. Зөвлөл нь орон тооны бус байна.

1.2. Зөвлөл нь үйл ажиллагааны чиглэлийн холбогдох хууль, Засгийн газрын тогтоол, бусад эрх зүйн баримт бичиг болон энэхүү журмыг удирдлага болгон зооноз, шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчний хүн, мал эмнэлэг бусад салбар хоорондын бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулж ажиллана.

1.3. Зөвлөл нь орон нутагт салбартай байх ба аймаг, Нийслэлийн Засаг даргын тушаалаар баталгаажуулсан байна.

1.4. Зөвлөл нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллана.

Хоёр. Зөвлөлийн удирдлага, зохион байгуулалт

2.1. Зөвлөлийн дарга нь Эрүүл мэндийн дэд сайд, орлогч дарга нь Үйлдвэр, хөдөө аж ахуйн дэд сайд, нарийн бичгийн дарга нь ЭМЯ-ны харъяа ЗӨСҮТ-ийн захирал байна. Зөвлөлийн даргыг эзгүйд түүний үүргийг орлогч дарга гүйцэтгэнэ. Техникийн ажлын хэсгийн дарга нь ЗГХА-МЭҮГ-ын дэд дарга, малын ерөнхий эмч байна.

2.2. Зөвлөлийн үндсэн үйл ажиллагаа нь зөвлөлийн гишүүдийн хурал байна. Зөвлөл нь улирал тутмын сүүлийн сард хуралдаж, “Нэг эрүүл мэнд” үзэл баримтлал болон зоонозын халдварт өвчний бодлогын баримт бичгийн хэрэгжилт, явц, үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар хэлэлцэх бөгөөд шаардлагатай үед зөвлөлийн дарга ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.

2.3. Зөвлөлийн хурлын шийдвэр нь тэмдэглэл хэлбэртэй байх ба зөвлөлийн нарийн бичгийн дарга гарын үсэг зурсанаар баталгаажина.

2.4. Зөвлөлийн гишүүдийн гуравны хоёр хувь хуралд ирсэнээр хүчинтэйд тооцогдох ба хүндэтгэн үзэх шалтгааны улмаас оролцож чадахгүй гишүүн саналаа бичгээр хүргүүлсэн байна.

2.5. Зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг зөвлөлийн нарийн бичгийн дарга нь техникийн ажлын хэсгийн гишүүд хамтран хангаж, хэлэлцэх асуудлын танилцуулга, шаардлагатай бусад материалыг хурал эхлэхээс 7 хоногийн өмнө зөвлөлийн гишүүдэд танилцуулсан байна. Хэлэлцэх асуудлаар ажлын хэсэг томилон ажиллуулж болно.

2.6. Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлаар дүгнэлт, санал бэлтгэх үүрэг бүхий шинжээч томилох, ажлын хэсэг байгуулах асуудлыг зөвлөлийн даргын шийдвэрээр хэрэгжүүлнэ.

182

2.7.Хуралд хэлэлцүүлэх асуудлын холбогдох баримт бичгийг зөвлөлийн нарийн бичгийн дарга хүлээн авч эцэслэн хянаж, хэлэлцүүлэх саналыг зөвлөлийн даргад танилцуулна.

2.8.Зөвлөлийн хуралд Эрүүл мэнд, Үйлдвэр хөдөө аж ахуйн сайд, холбогдох яам, агентлагийн удирдлагууд саналын эрхтэйгээр оролцож болно.

2.9.Зөвлөл нь жилийн ажлын үр дүнгээ дараа оны 1 дүгээр сард багтаан Эрүүл мэндийн яам, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яаманд танилцуулна.

2.10.Зөвлөлийн болон техникийн ажлын хэсгийн гишүүдэд ажлын үр дүнг харгалзан урамшуулал олгож болно.

Гурав. Зөвлөлийн үйл ажиллагааны хамрах хүрээ

Зөвлөл нь дараах үндсэн чиглэлээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ.

3.1.“Нэг Эрүүл Мэнд” үзэл баримтлалын хүрээнд салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан чиглүүлэх;

3.2.Салбар хооронд мэдээ, мэдээлэл солилцох;

3.3.Зооноз, шинэ болон сэргэж буй халдварт өвчний үед хамтарсан хариу арга хэмжээг зохион байгуулах бэлэн байдлыг хангах;

3.4.Эрсдэлийн үнэлгээ хийх;

3.5.Хамтарсан судалгаа, шинжилгээ хийх чиглэлийг тодорхойлох, үр дүнд санал, дүгнэлт өгөх;

3.6.ЭМЯ, ОБЕГ-ын дэргэд ажиллаж буй шуурхай удирдлагын төвтэй үйл ажиллагааг уялдуулан зохицуулж ажиллах.

Дөрөв. Зөвлөлийн үүрэг, эрх

4.1.Зооноз, шинэ болон сэргэж буй халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлаар салбарууд хамтран гүйцэтгэх үйл ажиллагааны бодлого, чиглэлийг тодорхойлох;

4.2.Бүх түвшинд салбаруудын хамтын ажиллагааг бэхжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;

4.3.Зооноз, шинэ болон сэргэж буй халдварт өвчний дэгдэлтийн үед хамтарсан баг томилж, эрсдлийн үнэлгээ хийх, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг оновчтой зохион байгуулах, мэргэжлийн зөвлөгөө өгөх;

4.4.Зоонозын халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний заавар, удирдамж, гарын авлагыг боловсруулах, нэмэлт оруулахад санал өгөх;

4.5.Үндэсний болон орон нутгийн түвшинд мэргэжлийн байгууллагуудын чадавхийг сайжруулах чиглэлээр санал дэвшүүлэх;

4.6.Зөвлөл нь “Монголын талбарын тархвар судлал” сургалтын хөтөлбөрийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх;

4.7.Батлагдсан төсөвт багтаан зөвлөлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, техникийн ажлын хэсгийн чиг үүргийг батлах;

4.8.Зөвлөлийн төсвийн төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэж дүгнэлт гаргах;

- 4.9. Зөвлөлийн үйл ажиллагаанд шаардлагатай мэдээ, мэдээлэл гаргуулах;
- 4.10. Зоонозын халдварт өвчний бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг зохион байгуулах талаар Засгийн газар, холбогдох төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангах;
- 4.11. ШУТ-ийн болон бусад төсөл, хөтөлбөрийг санаачлан боловсруулж, төрийн захиргааны байгууллагад танилцуулах, хэрэгжүүлэх.

Тав. Зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүдийн үүрэг, эрх

5.1. Зөвлөлийн ерөнхий үйл ажиллагааг зөвлөлийн дарга эсвэл дэд дарга удирдан зохион байгуулах бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 5.1.1. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тогтоох, хуралдааныг товлох, даргалах;
- 5.1.2. Зөвлөлийн гадаад, дотоод харилцааг зохицуулан төлөөлөх;
- 5.1.3. Зөвлөлийн техникийн ажлын хэсгийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг тогтоох, үйл ажиллагаанд хяналт тавих;
- 5.1.4. Зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулах арга хэмжээ авах;
- 5.1.5. Зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар техникийн ажлын хэсгийн даргад үүрэг даалгавар өгч гүйцэтгэлд нь хяналт тавих;
- 5.1.6. Зөвлөлөөс бусад байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтарч ажиллах асуудлыг шийдвэрлэх;
- 5.1.7. Зөвлөлийн үйл ажиллагааны төсвийг батлуулан зориулалтын дагуу захиран зарцуулах.

5.2. Зөвлөлийн гишүүн нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

- 5.2.1. Зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар техникийн ажлын хэсгийн даргад үүрэг даалгавар өгч, гүйцэтгэлд нь хяналт тавих;
- 5.2.2. Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудалд санал оруулах;
- 5.2.3. Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан нэмэлт баримт бичиг, мэдээлэл гаргуулан авах.

Зургаа. Техникийн ажлын хэсгийн гишүүдийн үүрэг, эрх

- 6.1. Техникийн ажлын хэсгийн гишүүд нь салбар хоорондын хамтын ажиллагаатай холбоотой үйл ажиллагааг тухайн салбартаа зохион байгуулж, ажлын уялдааг хангах;
- 6.2. Зөвлөлийн дарга, гишүүдийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж ажиллах;
- 6.3. Зөвлөлийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын төсөл боловсруулж, зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;

6.4. Зөвлөлийн шийдвэрийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтэд мэдээлэх;

6.5. Техникийн ажлын хэсгийн гишүүд нь салбар хоорондын хүрээнд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө, тушаал зааврын хэрэгжилтэд хяналт тавьж, зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх ажлыг зохицуулах.

Долоо. Бусад

7.1. Зөвлөл нь ажлаа бүтэн жилээр төлөвлөн хэрэгжүүлнэ.

7.2. Зөвлөлийн үйл ажиллагааны жилийн тайланг техникийн ажлын хэсэг бичих бөгөөд жил бүрийн 1 дүгээр сард багтаан зөвлөлийн дарга, гишүүдэд танилцуулсны дараа ЭМЯ, ҮХААЯ-нд хүргүүлнэ.

7.3. Зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг Эрүүл мэндийн болон мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний багцад тусган улсын төсөв, Олон улсын байгууллагын дэмжлэгээр санхүүжүүлнэ.

Эрүүл мэнд, Үйлдвэр, хөдөө аж а. йн сайдын
 2013 оны... дугаар тушаалын гуравдугаар хавсралт

“Нэг эрүүл мэнд” салбар хоорондын сургалт, судалгааны төвийн үйл ажиллагааны ерөнхий чиглэл, ажлын төлөвлөгөө (2013-2016)

Үйл ажиллагааны ерөнхий чиглэл:

Нэг. Салбар хоорондын хамтын ажиллагааны механизмдыг боловсронгуй болгох, салбарын оролцоог нэмэгдүүлж, өргөжүүлэх;
 Хоёр. Нийгмийн эрүүл мэндийн аюул, эрсдэлийг бууруулах чадаахыг бэхжүүлж, олон салбарын оролцоонд тулгуурлан нийгмийн эрүүл мэндийн аюул, эрсдэлтэй холбоотой үйл явдлын үр нөлөөг багасгах;
 Гурав. Хэрэглээнд суурилсан сургалтаар дамжуулан “Нэг Эрүүл мэнд” сүлжээ, хамтарсан судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлэх;

Дөрөв. Хоол, хүнснээс шалтгаалсан өвчний эрсдлийг бууруулах чадаахыг бэхжүүлсэнээр хүнсний аюулгүй байдлын болзошгүй аюул, эрсдлийг багасгах

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хэрэгжүүлэгч байгууллагууд			Санхүүжилтийн эх үүсвэр (сая. төгрөгөөр)	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн
			Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч байгууллага	Бусад оролцогч байгууллага			
<p>Чиглэл нэг: Салбар хоорондын хамтын ажиллагааны механизмдыг боловсронгуй болгох, салбарын оролцоог нэмэгдүүлж, өргөжүүлэх Хүрэх үр дүн: Зоонозын халдварт өвчний салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлсэнээр Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, халдварт өвчний дэгдэлтээс эрт сэргэмжлүүлэх, харуу арга хэмжээг шуурхай зохион байгуулж, эдийн засгийн хувьд үр дүнтэй үйл ажиллагааны тогтворжсон механизм бүрдэнэ.</p>								
1	Зоонозын халдварт өвчний салбар хоорондын зөвлөлийг өргөжүүлэн шинэчилж, эрхзүйн орчныг боловсронгуй болгон хэрэгжүүлэх	2013 оны 11-12-р сар	ЗӨСҮТ	МЭҮГ	Оролцогч байгууллагууд	Засгийн газар	Батлагдсан Тушаал	Салбар хоорондын зөвлөлийн эрхзүйн орчин бүрдэнэ.
2	“Нэг эрүүл мэнд” салбар хоорондын зөвлөлийн болон техникийн ажлын хэсгийн уулзалт зохион байгуулж, цаашдын чиглэлийг тодорхойлох	2013 оны 12-р сар	ЗӨСҮТ, МЭҮГ	МЭХ, УМЭАЦТЛ	Оролцогч байгууллагууд	Дэлхийн банк	Хурлын тэмдэглэл, шийдвэр	Цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл боловсронгуй болно.
3	“Нэг эрүүл мэнд” салбар хоорондын үйл ажиллагааг	2014 оны 1-р	ЗӨСҮТ, МЭҮГ	Зөвлөл, техникийн	Оролцогч байгууллагууд	Засгийн газар	Стратеги төлөвлөгөө	Стратегит үйл ажиллагааны чиглэл

өргөжүүлэх стратеги боловсруулан батлуулах	дунд хугацааны төлөвлөгөө	улирал	ажлын үзэсгэлэн	Оролцогч байгууллагууд	Засгийн газар	Шалгуур үзүүлэлт, Үнэлгээний журам	бол. дорногүй болсон байна.
4	Салбар хоорондын зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт-үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт боловсруулах, тогтолцоог бүрдүүлэх	2013 оны 12-р сар	МХЕГ, ОБЕГ, МЭХ, УМЭАЦЛ, МТТССХ	Оролцогч байгууллагууд	Засгийн газар	Шалгуур үзүүлэлт, Үнэлгээний журам	Хяналт-үнэлгээний тогтолцоо бүрдсэн байна.
5	"Нэг Эрүүл мэнд" үндэсний зөвлөгөөн зохион байгуулах	2013 оны 12-р сар	ЗӨСҮТ, МЭХ	Оролцогч байгууллагууд	Дэлхийн банк,	Зөвлөгөөний тайлан, зөвлөмж	Зөвлөгөөний зөвлөмж гарсан байна.
6	Өвчинд өвөрмөц арга хэмжээний хамтарсан стратеги төлөвлөгөөг боловсруулах, батлуулах	2013-2016	ЭМЯ, ҮХААЯ	Оролцогч байгууллагууд	Засгийн газар, ОУ-ын байгууллага,	Стратеги төлөвлөгөө	Өвчний чиглэлээр стратеги үйл ажиллагааны үр дүн сайжирсан байна.
<p>Чиглэл хоёр: Нийгмийн эрүүл мэндийн аюул, эрсдэлийг бууруулах чадварыг бэхжүүлж, олон салбарын оролцоо шаардагдах нийгмийн эрүүл мэндийн болзошгүй аюул, эрсдэлтэй холбоотой үйл явдлын үр нөлөөг багасгах</p> <p>Хүрэх үр дүн: Эрсдэлийг бууруулах, хамтарсан эрсдлийн үнэлгээ хийснээр салбар хоорондын уялдаа сайжирч, нотолгоонд суурилсан үйл ажиллагаа өргөжнө.</p>							
1	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эрсдлийн үнэлгээ хийх журам боловсруулах, батлуулах	2014 оны 1-р улирал	ЭМЯ, ҮХААЯ	Оролцогч байгууллагууд	ДЭМБ	Үнэлгээний журам	Эрсдлийн үнэлгээний ажил тогтмолжсон байна.
2	Үнэлгээний багийн гишүүдийг зайн болон ажлын байрны сургалтын хэлбэрээр сургаж дадлагажуулах	2014-2016	ЭМЯ, ҮХААЯ	Оролцогч байгууллагууд	Засгийн газар	Сургалтын төрөл, бэлтгэгдсэн мэргэжилтний тоо	Хүний нөөцийн чадавхи сайжирсан байна.
3	Хамтарсан эрсдлийн үнэлгээг тогтмолжуулж, үнэлгээний үр дүнг тайлагнах	2014-2016	ЗӨСҮТ, УМЭАЦЛ	Оролцогч байгууллагууд	ОУ-ын байгууллага	Эрсдлийн үнэлгээний тайлан	Хамтарсан эрсдлийн үнэлгээ хийж, зөвлөмж гарсан байна.
4	Дэгдэлтийн судалгаанд үнэлгээ хийх, зөвлөмжөөр хангах	2014-2016	ЗӨСҮТ, УМЭАЦЛ	Оролцогч байгууллагууд	Засгийн газар	Дэгдэлтийн судалгааны тайлан болон үнэлгээ хийгдсэн байна.	Дэгдэлтийн судалгааны тайлан болон үнэлгээ хийгдсэн байна.
5	APSED (2010)-ийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх журам, шалгуур үзүүлэлт боловсруулах, хэрэгжүүлэх	2013-2014 оны 1-р улирал	ЭМЯ, ҮХААЯ техникийн ажлын хэсэг	Оролцогч байгууллага	ДЭМБ	Үнэлгээний журам, шалгуур үзүүлэлт	Хяналт-үнэлгээний журам боловсрогдож хэрэгжсэн байна.
<p>Чиглэл гурав: Хэрэгжлэнд суурилсан сургалтаар салбар хоорондын мэргэжилтнүүдийг сурган дадлагажуулж, хамтарсан судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлэх</p>							

Хүрээх үр дүн: Хүний нөөцийн чадавхийг сайжруулснаар зоонозын халдас өвчний тугламдсан асуудлууд шийдвэрлэгдсэн байна.									
1	Талбарын тархвар судлалын сургалтад олон салбараас мэргэжилтэн суралцуулах, оролцоог нэмэгдүүлэх	2013-2016	Салбар хоорондын зөвлөл, ТТССТ	Оролцогч байгууллага	Оролцогч байгууллага	ДЭМБ, Дэлхийн банк	Суралцагсдын тоо	Сургалтад суралцагчдын тоо нэмэгдэж, өргөжсөн байна.	
2	Дэгдэлтийн судалгаа, улс орны нехцөл байдлыг тусгасан нийтийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн олон салбарын харуу арга хэмжээ авах, лабораторийн оношлогоо хийх тухай суралцах зарчим бүхий тохиолдлын судалгаа боловсруулах	2014	ТТССТ Салбар хоорондын зөвлөл,			ДЭМБ	Боловсруулсан тохиолдлын судалгаа	Суралцагчдын дадлага ажлын сайжирсан байна.	
3	ТТСС-ын хичээлийн хөтөлбөрт суурилан Мал эмнэлгийн ТТСС-ын хөтөлбөрийг боловсруулж, нэмэлт оруулах	2013-2014	ШХА, ТТССТ	МЭМТ, ТТССТ	Оролцогч байгууллага	ОУ-ын байгууллага	Батлагдсан хөтөлбөр	Сургалтын хөтөлбөрийн цар хүрээ өргөжсөн байна.	
4	"Нэг эрүүл мэнд" мэдээллийн сан бүрдүүлэх, цахим номын сан байгуулах, баяжуулах	2013-2014	ТТССТ	Оролцогч байгууллага		Дэлхийн банк	Мэдээллийн сан, цахим номын сан	Суралцагчдын сурах боломж бүрэн хангагдсан байна.	
5	Нэг эрүүл мэнд олон улсын HubNet нөөцийг ашиглан "Нэг эрүүл мэнд" датабааз, цахим номын сан, интернетээр суралцах, мэдээллийн бааз байгуулах, Нэг эрүүл мэнд олон улсын ресорс HubNet-тэй холбох	2013	ТТССТ, МЗУГ, ЗӨСҮТ, ХӨСҮТ, УМЭАЦТЛ, МЭХ	МХЕГ, ОБЕГ		Дэлхийн банк	Цахим мэдээллийн тогтолцоо	"Нэг эрүүл мэнд" hub-тэй холбогдож, мэдээллийн тогтолцоо боловсронгуй болсон байна.	
6	Хүн, мал эмнэлгийн салбар хоорондын сургалт, судалгааны төвийн албан тасалгааны тохижилтыг сайжруулах	2013	ТТССТ	МЗУГ, ЗӨСҮТ, УМЭАЦТЛ, МХЕГ, ОБЕГ, ХӨСҮТ, МЭХ		Дэлхийн банк	Иж бүрдэл тавилга	Албан тасалгааны тохижилт сайжирсан байна.	
7	Гахай болон гахайн бүтээгдэхүүнээр дамжин халдварлах халдварт өвчний лабораторид суурилсан тандалт хийх, зөвлөмж боловсруулах, журам боловсруулах, батлуулах	2013-2014 оны 1-р улирал	ЗӨСҮТ, УМЭАЦТЛ, МХЕГ	МЭХ		ДЭМБ	Тандалтын тоо, судалгааны үр дүн	Гахайгаар дамжих халдварт тандалтын тогтолцоо боловсронгуй болсон байна.	
8	Нохойн бруцеллэз өвчний	2014-	МЭХ,	ЗӨСҮТ, ХӨСҮТ		ШУТС	Тандалт	Нохойн бруцеллэз өвчний	

Талаар хамтарсан судалгааны ажил хийх	2016					Судалгааны тоо, үр дүн	Тандалт судалгааны үр дүнд суулгасан зөвлөмж гарсан байна.
9	Бруцеллёзын нутгийн омог, стандарт ялган авах эмнэлзүйд суурилсан тандалт судалгааны ажлыг гүйцэтгэх	2014	ЗӨСҮТ	УМЭАЦТЛ		Тандалт судалгааны удирдамж Тайлан	Бруцеллёз оношилгооны чадавхи сайжирсан байна.
10	УМЭАЦТЛ, ЗӨСҮТ-ийн хамтарсан идэвхтэй тандалт судалгааны үр дүн (2008-2013)-г хэлэлцүүлэх семинар зохион байгуулах	2014 оны 1-р улирал	ЗӨСҮТ	УМЭАЦТЛ		ДЭМБ	Хүн, малын дундах тандалт судалгааны цаашдын чиглэл боловсронгуй болсон байна.
11	Шимэгчээр дамжин халдварлах халдварт өвчний тандалтын тогтолцоог бүрдүүлэх, судалгаа шинжилгээний ажил хийх, стратеги төлөвлөгөө боловсруулах	2014 оны 1-р улирал	УМЭАЦТЛ, МЭХ	ЗӨСҮТ		ДЭМБ	Шимэгчээр халдварт өвчний тандалтын тогтолцоо боловсронгуй болсон байна.
12	Хачгаар дамжих халдварт өвчний тандалт судалгааг өргөжүүлэх	2014-2016	ЗӨСҮТ	МЭХ, УМЭАЦТЛ		ОУ-ын байгууллага, Засгийн газар	Хачгаар дамжих халдварт өвчний тандалт судалгаа өргөжсөн байна.
13	Зооноз, био-аюулгүй байдал, орчны эрүүл ахуйг хангах чиглэлээр туршлага судлах	2014-2016	Салбар хоорондын зөвлөл	Оролцогч байгууллага		ДЭМБ	Зооноз, био-аюулгүй байдлын чиглэлээр үйл ажиллагаа сайжирсан байна.
14	"Нэг эрүүл мэнд" НУВ-ын чиглэлээр туршлага судлах	2013-2016	Салбар хоорондын зөвлөл	Оролцогч байгууллага		ОУ-ын байгууллага, Засгийн газар	"Нэг эрүүл мэнд" НУВ чиглэлээр үйл ажиллагаа сайжирсан байна.
15	"Бруцеллёзын нийгмийн эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө болон бруцеллёзтой стратеги, тэмцэх арга хэмжээ" сэдэвт зөвлөгөөн зохион байгуулах	2013 оны 11-р сар	МЭХ	ЗӨСҮТ, УМЭАЦТЛ		ОУ-ын байгууллагууд	Бруцеллёз өвчинтэй тэмцэх, сэргийлэх чиглэл боловсрогдсон байна.
16	Хүн амд чиглэсэн мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг өргөжүүлэх	2014-2016	Салбар хоорондын зөвлөл	Оролцогч байгууллага		ОУ-ын байгууллага, Засгийн газар	Хүн амын дундах мэдээлэл, сургалт сурталчилгааны үйл ажиллагаа өргөжсөн байна.
17	Хүн, мал эмнэлгийн салбарын лабораторийн чадавхид үнэлгээ	2014-2016	Салбар хоорондын зөвлөл	Оролцогч байгууллага		ОУ-ын байгууллага,	Лабораторийн гадаад чанарын хяналт

Хийх, олон улсын лабораторийн сүлжээнд хамрагдах	Зөвлөл	МЭХ, УМЭАЦТЛ, МХЕГ, ОБЕГ, ХӨСҮТ, МЭХ, УМЭАЦТЛ	Бусад байгууллагауд	Засгийн газар	сай, усан байна.
18 Зоонозын халдварын тандалт, лабораторийн сүлжээ байгуулах, хэрэгжүүлэх	МЭҮГ, ЗӨСҮТ, 2014-2016	МЭХ, УМЭАЦТЛ, МХЕГ, ОБЕГ, ХӨСҮТ, МЭХ, УМЭАЦТЛ	Бусад байгууллагауд	ОУ-ын байгууллага	Зоонозын өвчний тандалтын сүлжээ боловсронгуй болсон байна.
19 Лабораторийн үр чадвар, сорилын үнэлгээг хийх тогтолцоог боловсронгуй болгох	МЭҮГ, ЗӨСҮТ, 2014-2017	МЭХ, УМЭАЦТЛ	МХЕГ, ОБЕГ, ХӨСҮТ, бусад байгууллага	ОУ-ын байгууллага, Засгийн газар	Тогтолцоо бүрдсэн байна.
20 Биологийн аюултай сорьц, илгээмж тээвэрлэх асуудлыг зохицуулах, эрхзүйн орчныг шинэчлэн батлуулах	ЭМЯ, УХААЯ, 2014	МЭХ, УМЭАЦТЛ, ЗӨСҮТ,		Засгийн газар	Биоаюултай сорьц тээвэрлэх эрхзүйн орчин бүрдэж, хэрэгжсэн байна.
Циглэл дөрөв: Хоол, хүнсээс шалтгаалсан өвчний эрсдлийг бууруулах чадварыг бэхжүүлсэнээр хүнсний аюулгүй байдлын болзошгүй эрсдлийг багасгах					
Хүрэх үр дүн: Эрсдлийг бууруулах, хамтарсан эрсдлийн үнэлгээ хийснээр салбар хоорондын уялдаа сайжирч, нотолгоонд суурилсан үйл ажиллагаа өргөжнө.					
1 Хүнсний сүлжээний бүх үе шатанд ул мөрийг мөрдөн тогтоох тогтолцоог нэвтрүүлэх журам, аргачлал боловсруулж батлуулах	УХААЯ, МХЕГ, 2013-2014	ЭМЯ	МЭҮГ	ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар	Тогтолцоог нэвтрүүлэх эрх зүйн зохицуулалттай болно.
2 Шаардлага хангахгүй хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг буцаан болон татан авах тогтолцоог нэвтрүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх	МХЕГ, 2013-2016	УХААЯ, ЭМЯ	МЭҮГ, НЭМҮТөв БОНХЯ-ны БАБУХ	ДЭМБ-ын Монгол дахь төлөөлөгчийн газар	Мэдээллийн сантай болж, шаардлага хангахгүй татан авсан бүтээгдэхүүний талаар хэрэглэгч мэдээлэл авах нөхцөл бүрдэнэ.
3 Хүнсний сүлжээний үе шат бүрт зохистой дадлыг нэвтрүүлэх талаар /GMP, GAP, GHP/ зөвлөмж боловсруулж батлуулах, улсын байцаагч, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд сургалт зохион байгуулах	УХААЯ, МХЕГ, 2013-2014	ЭМЯ, НЭМҮТөв	МЭҮГ	Дэлхийн банк	Заавар, зөвлөмж боловсруулж батлагдсан байна. Улсын байцаагч, ХЧҮАЭ-д зохистой дадлын талаар мэдээлэлтэй болно. Зохистой дадлыг нэвтрүүл сэнээр эрсдэлгүй үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах нөхцөл бүрдэнэ.
4 Импортын бүтээгдэхүүний эрсдлийг үнэлэх журам	МХЕГ, 2014	ЭМЯ, УХААЯ НЭМҮТөв	МЭҮГ, БОНХЯ-ны БАБУХ	ДЭМБ	Заавар, зөвлөмж боловсруулж батлагдсан байна. Шалгуур үзүүлэлт, журам боловсруулж батлуулсан

	боловсруулж, батлуулах									бай. Импортын, Түтээгдэхүүний эрсдлийг үнэлэх эрх зүйн орчин бүрдэнэ.
5	Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх талаар улсын байцаагч нарыг сургах	2013-2014	МХЕГ	ЭМЯ, УХААЯ	МЭҮГ, НЭМҮТөв БОНХЯ-ны БАБУХ	ДЭМБ	Сургалтын оролцогчдын тоо	Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх талаар улсын байцаагч нар мэдлэгтэй болсон байна.		
6	Хүнсний сүлжээний бүх шатанд хийсэн эрсдлийн үнэлгээнд дүн шинжилгээ хийж, авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж ажиллах	2014	МХЕГ, НТЛ	ЭМЯ, УХААЯ НЭМҮТөв	МЭҮГ, ХӨСҮТ, БОНХЯ-ны БАБУХ	ДЭМБ	Дүн шинжилгээний тайлан	Хүнсний сүлжээний бүх шатанд хийсэн эрсдлийн үнэлгээнд дүн шинжилгээ хийж, авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулсан байна.		
7	Хүнсний аюулгүй байдлын талаар шинээр цахим хуудас ажиллуулах	2013-2014	МХЕГ	ЭМЯ, УХААЯ	ХӨСҮТ, МЭҮГ, НЭМҮТөв БОНХЯ-ны БАБУХ	ДЭМБ	Цахим хуудасны баяжилт	Хүнсний аюулгүй байдлын талаар цахим хуудас ажиллуулдаг болсон, хэрэглэгч мэдээлэл авах нөхцөл бүрдэнэ.		
8	Хилийн боомтод ОУЭМД-ээр зохицуулагддаг халдварт өвчний тохиолдол илэрсэн үед хариу арга хэмжээ авах журам боловсруулж, батлуулах	2013-2014	МХЕГ, ЭМЯ	ЗӨСҮТ, ХӨСҮТ	УХААЯ	ДЭМБ	Журам	Журам боловсруулж батлагдсан, хилийн боомтод эрсдэл үүссэн тохиолдолд хариу арга хэмжээ авах эрх зүйн орчин бүрдэнэ.		